

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2015 оны 1<sup>д</sup> дугаар  
сарын 23-ны .... өдөр

Дугаар... А.НЗН А/989

Улаанбаатар хот


Агаарын чанарыг сайжруулах бүсийг  
шинэчлэн тогтоох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсэд хамрагдах хороодыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Нийслэлд агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс шинэчлэн тогтоосон талаар олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хэвлэл мэдээллийн алба /Г.Ганхуяг/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах хэлтэс /Я.Мөнгөнцэцэг/, дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.





A/434

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАА ВИЛ САЙЖРУУЛАХ БҮСЭД  
ХАМРАГДАХ ДҮҮРЭГ, ХОРООДЫН ТОО

Дүүрэг	Хороодын дугаар, бүсийн ангилал		
	1-р бүс	2-р бүс	3-р бүс
	Утаагүй бүс (орон сууцын хороолол)	Сайжруулсан түлш хэрэглэх бүс	Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн (сайжруулсан зуух, цахилгаан болон хийн халаагуур, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр г.м) хэрэглэх бүс
БГД	1,2,3,4,5,6,8,12,13,14, 15,17,18,19	7,9,10,11,16,20,21, 22,23	
СХД	12,13,14,15,16,17,29		1,2,3,4,5,6,7,8,9,10,11,18,19,20,21,22,23,24, 25,26,27,28,30,31,32
ЧД	1,2,3,4,5,6		7,8,9,10,11,12,13,14,15,16,17,18,19
СБД	1,2,3,4,5,6,7,8,10		9,11,12,13,14,15,16,17,18,19,20
ХУД	1,15		2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13,14,16
БЗД	1,3,6,7,15,18,25,26		2,4,5,8,9,10,11,12,13,14,16,17,19,20,21,22,23,24, 27,28
Хамрагдах хорооны тоо	46	9	83
Дүн	138		

# НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС 2015-2016 ОН

